Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Сургалтын байгууллагын хөгжил, хүний нөөцийн удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Баярмагнай Мөнхзаяа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах | | | | | | | |
| 1 | Цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулна. | Баримт бичиг | БСШУС-ын сайдын 2019 оны А/854 дүгээр тушаал | Журам шинэчлэн батлуулсан байна. | "Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-ыг боловсруулан, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай А/95 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Мэргэшлийн зэрэг олгох нь албан тушаалын үндсэн чиг үүргээ гүйцэтгэл, үр дүн сайтай хэрэгжүүлсэн, мэргэшлийн ур чадвар, арга зүй туршлагаараа | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага, орон нутаг, улсын хэмжээнд манлайлан, бусдад түгээн дэлгэрүүлж, хамтран суралцах, зөвлөн чиглүүлэх түвшинд хүрсний баталгаа болох бөгөөд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Журмаар багш, удирдах ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан, ил тод, нээлттэй, мэргэжлийн үнэ цэнэ, нэр хүндийг эрхэмлэсэн, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нээлттэй, ил тод байх зарчим баримтлахаар журамласан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 2 | Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйч, багшийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага боловсруулж батлуулна. | Баримт бичиг | БСШУС-ын сайдын 2019 оны А/430 дугаар тушаал | Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. | "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага" болон "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага"-ыг Боловсролын сайдын | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн “Нийтлэг шаардлага батлах тухай” А/107 дугаар тушаалын хавсралтаар тус тус батлуулан Боловсролын ерөнхий газарт 2027.09.27-ны өдрийн 12/1242 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тушаалын хавсралтаар баталсан нийтлэг шаардлагад нийцүүлэн цэцэрлэгийн багш, арга зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус даалгасан. Хавсралт: 1 файл | | байдал: 100% |
| 3 | "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам" шинэчлэн боловсруулж батлуулна. | Баримт бичиг | БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаал | Журам шинэчлэн батлуулсан байна. | "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11- | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ний өдрийн А/115 дугаар тушаалаар батлагдсан. "Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ"-ний зорилго сургалт, үйл ажиллагааны чанар, хүүхдийн хөгжлийн ахиц үр дүнг үнэлж, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааны чанарыг сайжруулах, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг төлөвшүүлэхэд чиглэгдсэн. | | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 4 | Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, хүүхдийн цэцэрлэгийн салбар бүлгийн орон тооны хязгаарын жишиг нормативын төсөл боловсруулж, батлуулна. | Баримт бичиг | Төсөл боловсруулсан | Жишиг нормативыг батлуулсан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн албан хаагчдын орон тооны жишиг норматив, хүүхдийн цэцэрлэгийн дэргэдэх салбар бүлгийн албан хаагчдын орон тооны хязгаарын жишиг норматив болон хүүхдийн цэцэрлэгийн дэргэдэх салбар бүлгийн орон тооны жишиг нормативыг хэрэгжүүлэх нийтлэг аргачлал батлагдсан. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангиний сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 26- | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрийн А/85, А/134 дүгээр тушаалаар "Орон тооны хязгаарын жишиг норматив" батлагдан гарч 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж байна. Хавсралт: 1 файл | | |
| 1.2. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 5 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн ажлыг үнэлэх, дүгнэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангана. | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургалтын байгууллага болон багшийн үнэлгээний үр дүн | Цэцэрлэг /байгууллага/ - 90.2 Цэцэрлэг /багш/ - 90.11 | Цэцэрлэг /байгууллага/ - 92 Цэцэрлэг /багш/ - 92 | Сургуулийн өмнөх боловсролын багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд шинжилгээ хийсэн бөгөөд анхаарах асуудал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны санал боловсруулан, нэгжийн даргад танилцуулсан. Сургалт, үйл ажиллагааны үр дүн-90,7 Хүүхдийн хөгжлийн ахиц үр дүн-92,1 Орчинд эрүүл аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт хангаж ажилласан ажлын үр дүн-95,0 /БӨ аймаг- 84,9, Багахангай-88,9, Говьсүмбэр аймаг-89,8/ Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах болзошгүй эрсдлэлд өртөхөөс сэргийлж, осол гэмтэлгүй ажилласан ажлын үр дүн-76,7 байна. Багшийн | 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжлийн хөгжлийн ахиц үр дүн-13,5 (цэцэрлэгээр) Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөлт, биелэлт, үр дүн-90,3, Ажлын байранд мэргэжлийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, хамтран ажиллах, туршлагаа хуваалцах ажлын гүйцэтгэлийн үр дүн-80,9 Сургалт, үйл ажиллагаанд тоглоом наадгай, хэрэглэдэхүнийг бэлтгэж ашигласан ажлын үр дүн-83,0 Багшийн ёс зүй хэмж хэмжээг мөрдөж ажилласан үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн-95,0тай байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд ажиллаж буй багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх журмын тохирц, нийцлийг турших ажлын удирдамжид санал өгч ажилласан. Удирдамжид багшийн чадамжийг үнэлэх даалгавар боловсруулах ажил шинээр төлөвлөгдөж, Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмыг сайжруулах, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эцэслэн боловсруулах, батлуулах ажлыг холбогдох байгууллага, нэгжүүдтэй хамтран хийж хэрэгжүүлэхэр ажиллаж байна. | | |
| 6 | Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөмж боловсруулан цахим сургалт зохион байгуулна. | Боловсруулсан зөвлөмж, сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо | - | Зөвлөмж боловсруулж, цахим сургалтад 1410 удирдах ажилтан хамрагдсан байна. | Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг удирдлага зохицуулалтаар хангах зөвлөн туслах ажлын багт ажилласан. Хүүхдийн цэцэрлэгийн менежментийн сайн загварыг туршин хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, байгууллагын болон стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөө болон байгууллагын өөрийн үнэлгээнд дэмжлэг үзүүлэх, хөндлөнгийн үнэлгээ хийх зорилгооор Баянзүрх (82,147,167,203), Налайх дүүргийн (279, 152, 208) цэцэрлэгүүдэд ажиллаж, эрхлэгч арга зүйч нийт 220 хүнд "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйг дэмжих арга зүй" сэдэвт сургалт зохион байгуулсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 1.3. Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | | | |
| 7 | Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | - | - | - | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмын төсөлд санал оруулж, хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж байна. Цэцэрлэгийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргээс сонгогдсон 30 цэцэрлэгт хэрэгжиж, байгууллагын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг тооцож гаргана. Энэхүү үнэлгээний үр дүнд үндэслэн цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтэд бодит санал, өөрчлөлтийг тусган сайжруулахаар ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.4. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | | | | | | | |
| 8 | Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, | - | - | - | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын | 1-р сар, 2-р сар, 3-р | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | | | | салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хүрээнд: -Сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчлэн боловсруулж буй сургалтын хөтөлбөрийн 2 удаагийн хэлэлцүүлэгт санал өгч, тохирц, нийцлийг түшиц цэцэрлэгт шалган турших цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалтад оролцлоо. -сургуулийн өмнөх боловсролын хүний нөөцийн өнөөгийн байдал, тулшамдсан асуудал, шийдлийн талаар танилцуулга бэлтгэсэн. 2024-2025 оны хичээлийн жилд 1407 цэцэрлэгт 35.339 мянган албан хаагч ажиллаж байна. Үүнээс эрхлэгч 1339 /3,8%/, арга зүйч 1034 /2,9%/, үндсэн багш /бүлгийн, хөгжмийн, биеийн тамир/ 9945 /28,0%/, багшийн туслах 8743 /25%/, бусад ажилчид 14,278 /40,5%/-ийг эзэлж байна. Энэ хүрээнд цаашид багшийг ажлын байранд дахь мэргэжлийн хамтын ажиллагааг сайжруулж, | сар, 4-р сар, 5-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын бүлэг, багаар хамтран ажиллах чиглэлээр болон, багш ажилтны бүтээлч үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах, багш бэлтгэх, багш мэргэжлийг сонгох хүртэлх замын зураглал боловсруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. - Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн "Мэргэшлийн зэрэг олгох тухай" А/90 дүгээр тушаал боловсруулан, "Зөвлөх багш" мэргэшлийн зэрэг олгох хүүхдийн цэцэрлэгийн багш, удирдах ажилтны нэрсийг хавсралтаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. "Зөвлөх багш" мэргэшлийн зэргийг багш, арга зүйч, эрхлэгч нийт 42 хүн авсан. -Боловсрол, шинжлэх ухааны сайд болон “НҮБ-ын Хүүхдийн Сан”-ийн Суурин Төлөөлөгч Эваристе Каусси Комлан нарын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уулзалтыг зохион байгуулж, 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөөг батлуулан холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. 2024 оны төлөвлөгөөнд алслагдсан орон нутгийн малчдын хүүхдүүд, ядуу өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд СӨБ-ын чанартай үйлчилгээнд хамруулах, өсвөр үеийнхэн сэтгэцийн хувьд эрүүл байх, Хүүхэд, өсвөр үе, эмэгтэйчүүдийн хоол тэжээл, Хүүхэд хамгаалаллын асуудлууд орсон болно. Хавсралт: 3 файл | | |
| 1.5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | | | | | | | |
| 9 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | - | - | Боловсруулж батлуулж буй журамд ажлын үр дүнд суурилсан, бодитой, ил тод, хамтын оролцоог хангасан, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ялгаварлан гадуурхалт болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нийтлэг зүйлийг тусган оруулж байгаа бөгөөд зохион байгуулсан үйл ажиллагааг хуулийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд мэдээлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна. | | байдал: 100% |
| 10 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | - | - | Боловсруулж батлуулж буй журамд ажлын үр дүнд суурилсан, бодитой, ил тод, хамтын оролцоог хангасан, аливаа хөндлөнгийн нөлөөлөл, ялгаварлан гадуурхалт болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нийтлэг зүйлийг тусган оруулж байгаа бөгөөд зохион байгуулсан үйл ажиллагааг хуулийн хүрээнд мэдээлэн, хэрэгжүүлэн ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3.1. Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 11 | Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ. | - | - | - | Боловсролын салбарт буй үйлчилгээг цахимаар үзүүлэхэд хоблогдох байгууллага, нэгжүүдтэй хамтран ажиллаж байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 12 | Урт, дунд, богино | - | - | - | Урт, дунд, богино | 1-р сар, 2-р | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах | | | | хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж ажилласан. | сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3.2. Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | | | |
| 13 | Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ, олон улсын үнэлгээг зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангах | - | - | - | Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журмын төсөлд санал оруулж, хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж байна. Цэцэрлэгийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргээс сонгогдсон 30 цэцэрлэгт хэрэгжиж, байгууллагын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг тооцож гаргана. Энэхүү үнэлгээний үр | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүнд үндэслэн цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтэд бодит санал, өөрчлөлтийг тусган сайжруулахаар ажиллаж байна. | | |
| 3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | | | | | | | |
| 14 | Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | - | - | - | Япон улсын Тоёо их сургуулийн Хүний хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан 4 удаагийн Хүмүүнлэгийн ухааны судалгааны хүрээлэнгийн төслийн хүрээнд "Орон нутгийн дэмжлэг ашиглан хүүхдэд зөвлөгөө өгөх" арга зүйн сургалтыг төлөвлөн, Нийслэлийн Боловсролын газарт чиглэл өгч 2024 оны 10, 11 дүгээр сард "Цэцэрлэг бага сургуулийн залгамж холбоо, хамтын ажиллагаа тасралтгүй дэмжлэг" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 300 багшийг хамруулсан.<br>Хавсралт: 2 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | | | | | | | |
| 15 | Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах | - | - | - | Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хүрээнд: -Сургуулийн өмнөх боловсролын сургалтын шинэчлэн боловсруулж буй сургалтын хөтөлбөрийн 2 удаагийн хэлэлцүүлэгт санал өгч, тохирц, нийцлийг түшиц цэцэрлэгт шалган турших цэцэрлэгийн багш нарт зориулсан сургалтад оролцлоо. -сургуулийн өмнөх боловсролын хүний нөөцийн өнөөгийн байдал, тулшамдсан асуудал, шийдлийн талаар танилцуулга бэлтгэсэн. 2024-2025 оны хичээлийн жилд 1407 цэцэрлэгт 35.339 мянган албан хаагч ажиллаж байна. Үүнээс эрхлэгч 1339 /3,8%/, арга зүйч 1034 /2,9%/, үндсэн багш /бүлгийн, хөгжмийн, биеийн тамир/ 9945 /28,0%/, багшийн туслах 8743 /25%/, бусад ажилчид 14,278 /40,5%/-ийг эзэлж байна. Энэ хүрээнд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цаашид багшийг ажлын байранд дахь мэргэжлийн хамтын ажиллагааг сайжруулж, сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн багш нарын бүлэг, багаар хамтран ажиллах чиглэлээр болон, багш ажилтны бүтээлч үйл ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллах, багш бэлтгэх, багш мэргэжлийг сонгох хүртэлх замын зураглал боловсруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. -Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн "Мэргэшлийн зэрэг олгох тухай" А/90 дүгээр тушаал боловсруулан, "Зөвлөх багш" мэргэшлийн зэрэг олгох хүүхдийн цэцэрлэгийн багш, удирдах ажилтны нэрсийг хавсралтаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. "Зөвлөх багш" мэргэшлийн зэргийг багш, арга зүйч, эрхлэгч нийт 42 хүн авсан. -Боловсрол, шинжлэх ухааны сайд болон “НҮБ-ын Хүүхдийн Сан”-ийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурин Төлөөлөгч Эваристе Каусси Комлан нарын уулзалтыг зохион байгуулж, 2024 оны хамтран ажиллах төлөвлөгөөг батлуулан холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. 2024 оны төлөвлөгөөнд алслагдсан орон нутгийн малчдын хүүхдүүд, ядуу өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд СӨБ-ын чанартай үйлчилгээнд хамруулах, өсвөр үеийнхэн сэтгэцийн хувьд эрүүл байх, Хүүхэд, өсвөр үе, эмэгтэйчүүдийн хоол тэжээл, Хүүхэд хамгаалаллын асуудлууд орсон болно. | | |
| 3.5. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах | | | | | | | |
| 16 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах | - | - | - | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллаж байна. | | байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хүний нөөцийн менежментийн ур чадвараа дээшлүүлнэ. | Хүний нөөцийн менежментийн сургалтад хамрагдсан байна. | - | Нэг удаагийн сургалтад хамрагдсан байна. | БНСУ-ын Боловсролын яам, Эдийн Засгийн мэдээ сонин, Мэргэжлийн ур чадварын судалгааны төв хамтран "Global HR Forum-2024" Олон улсын хүний нөөцийн 19 дэх удаагийн форумыг "Хиймэл оюун ухааны шилжилт ба Хүн" сэдвээр 2024 оны 10 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд энэхүү форумд цахимаар оролцсон. | 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын чиглэлээр мэдлэгээ дээшлүүлнэ. | Сурган, сэтгэл судлалын чиглэлээр ном гарын авлага уншиж, тэмдэглэл хөтлөх | - | - | Япон улс болон БНТУ-д зохион байгуулагдсан "Тэгш хамран сургах боловсрол" сэдэвт 2 удаагийн сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сургалтын байгууллагын хөгжил, хүний нөөцийн удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Баярмагнай Мөнхзаяа
/................................................/                    Огноо: ........................